



НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН
ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДАД

НИЙСЛЭЛИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Жанжин Д. Сүхбаатарын талбай 7, 1 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160-0035
Утас/Факс: (976-11) 32-71-99
Цахим хуудас: www.ulaanbaatar.mn

2022.08.24 № 03/4291
танай _____ -ны № _____ -т

Журмын хэрэгжилтийг хангаж
ажиллах тухай

Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1106 дугаар захирамжаар шинэчлэн баталсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам”-ыг хүргүүлж байна.

Хөгжлийн бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг нийслэлийн нутаг дэвсгэрт зохион байгуулах, тэдгээрийн хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг үнэлж, дүгнэх ажлыг 2023 оноос эхлэн уг журмын дагуу зохион байгуулах тул хэрэгжилтийг ханган, үр дүнг тооцон ажиллах.

Тус журмын 1 дүгээр хавсралтад заагдсан тайлан, мэдээнүүдийн хэрэгжилт, үр дүнг тооцож, тогтоосон хугацаанд нь холбогдох байгууллага, нэгжүүдэд тайлагнаж ажиллахыг мэдэгдье.

Хавсралт 14 хуудастай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



И.БААТАРХҮҮ



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 23 өдөр

Дугаар А/1106

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.10.4 дэх заалт, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам"-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (И.Баатархүү)-т даалгасугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам батлах тухай" Нийслэлийн Засаг даргын 2017 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн А/335 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ

Д.СУМЪЯАБАЗАР



111020005163

Нийслэлийн Засаг даргын 2022 оны
08 дугаар сарын 22-ны өдрийн
А.Н.О.Б. дугаар захирамжийн
хавсралт

НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ,
МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН БҮРДҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмын зорилго нь хөгжлийн бодлогын баримт бичиг, Монгол Улсын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны үр дүнг үнэлж дүгнэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

1.2.Журамд хэрэглэсэн нэр томъёог Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 2.1-д тодорхойлсон утгаар ойлгож хэрэглэнэ.

Хоёр.Хяналт-шинжилгээ, үнэлгээний зарчим, хамрах хүрээ

2.1.Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 3.1 д заасан зарчмуудыг баримтална.

2.2.Энэ журмыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг, дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар, Захирагчийн харьяа нийслэлийн төсөвт болон аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудад мөрдөх бөгөөд хяналт-шинжилгээ, үнэлгээний хамрах хүрээнд бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, үйл ажиллагаа хамаарна.

2.2.1. Бодлогын баримт бичигт дараах баримт бичиг хамаарна:

- “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого;
- Хөгжлийн зорилтот хөтөлбөр;
- Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл;
- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр;
- “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”
- “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр”;
- “Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө”;
- Нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл;
- Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр;
- “Нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө”;

2.2.2.Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрт дараах баримт бичиг хамаарна:

- Монгол Улсын хууль;
- Улсын Их Хурлын тогтоол;
- Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол;
- Ерөнхийлөгчийн зарлиг;
- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр;

- Засгийн газрын тогтоол;
- Ерөнхий сайдын захирамж;
- Засгийн газрын хуралдааны тэмдэглэл;
- Засгийн газрын болон Ерөнхий сайдын албан даалгавар;
- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, шийдвэр;
- Нийслэлийн Засаг даргын захирамж;
- Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдааны тэмдэглэл;
- Нийслэлийн Засаг даргын албан даалгавар;
- Нийслэлийн Онцгой комиссын шийдвэр.

2.2.3.Захиргааны байгууллагын үйл ажиллагааны хүрээнд дараах асуудлууд хамаарна:

- Энэ журмын 2.2.1, 2.2.2-т заасан баримт бичгийн хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа;
- Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээг үнэлэх шалгуур үзүүлэлтийн биелэлт;
- Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт;
- Стратеги төлөвлөгөөний биелэлт;
- Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт;
- Ил тод байдлыг хангах талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагаа;
- Шилэн дансны хөтлөлт;
- Шударга байдлыг хангах талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагаа;
- Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт;
- Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт;
- Хэрэглэгчийн үнэлгээний тайлан;
- Улсын болон нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа ажил;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа ажил;
- Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр.

Гурав.Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын
үйл ажиллагаанд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээний
ажлын удирдлага, зохион байгуулалт

3.1.Нийслэлийн нутгийн захиргааны бүх шатны байгууллага нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үүрэг бүхий нэгж, ажилтантай байна.

3.2.Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага нь Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 4.6-д заасан шаардлага хангасан иргэнийг хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх албан тушаалд томилно.

3.3.Нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлэх, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг үнэлж дүгнэх ажлыг нийслэлийн хэмжээнд нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж, биелэлтэд нь хяналт тавих, мэдээлэх үүргийг хариуцна.

3.4.Энэхүү журмын 3.3-т заасан үүргийг тухайн нутаг дэвсгэрийн хүрээнд дүүрэг, хорооны Засаг дарга, нутгийн захиргааны байгууллагад дарга (захирал) нар тус тус хариуцна.

3.5.Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу нутгийн захиргааны байгууллагын бодлогын

баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дээд шатны байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

3.6.Албан тушаалтан нь бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны тайланг тогтоосон хугацаанд үнэн зөв, бодитой гаргаж өгөх үүрэгтэй.

Дөрөв.Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан
ажилтны эрх, үүрэг

4.1.Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх албан хаагч нь Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 5.1-д заасан эрхийг эдэлж, 5.2-т заасан үүргийг хүлээнэ.

Тав.Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагад
хийх хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын
төлөвлөлт, арга зүй, хариуцлага

5.1.Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын төлөвлөлт:

5.1.1.нийслэлийн нутгийн захиргааны байгууллага тухайн жилд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын төлөвлөгөөг жил бүр батлах бөгөөд уг төлөвлөгөө нь хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгжийн үйл ажиллагааны төлөвлөгөөний үндсэн хэсэг болно;

5.1.2.нийслэл, дүүргийн хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын төлөвлөгөөг тухайн шатны Засаг даргын Тамгын газрын дарга, байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөөг байгууллагын дарга /захирал/ тус тус батална;

5.1.3.нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд тогтмол хийх хяналт-шинжилгээний ажлыг гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан хугацаанд, шаардлагатай тохиолдолд эрх бүхий удирдлагаас баталсан удирдамжийн дагуу, үнэлгээний ажлыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, захирамжлалын баримт бичгүүдэд заасан хугацаанд тус тус гүйцэтгэнэ;

5.1.4.нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын жилийн үйл ажиллагаанд хийх үнэлгээний ажлыг дараа жилийн 1 дүгээр улиралд багтаан Нийслэлийн Засаг даргын Тамгын газар зохион байгуулна;

5.1.5.Нийслэлийн Засаг дарга шаардлагатай гэж үзвэл нутгийн захиргааны байгууллагын хагас жилийн үйл ажиллагааны явц, үр дүнд хийх үнэлгээг тухайн жилийн 3 дугаар улиралд хийж болно;

5.1.6.нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Нийслэлийн Засаг дарга томилж, ажиллах удирдамжийг батална. Ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн албан хаагч ажиллана;

5.1.7.Нийслэлийн Засаг даргын Тамгын газар баримт бичгийн үр дүн, үр нөлөөг судлах, захиргааны байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор хэрэглэгчийн үнэлгээ буюу судалгааг хийнэ;

5.1.8.Нийслэлийн Засаг даргын Тамгын газар урт болон дунд хугацаанд хэрэгжих бодлогын баримт бичгийн явцын болон эцсийн үнэлгээний аль ч шатанд үр нөлөөний үнэлгээг хөндлөнгийн байгууллагаар хийлгэж дүнг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ;

5.1.9.Нийслэлийн Засаг даргын Тамгын газар хяналт-шинжилгээ, үнэлгээг газар дээр нь хийх, эрдэмтэн, судлаачдыг үнэлгээ хийхэд татан оролцуулах, хэрэглэгчийн болон хөндлөнгийн үнэлгээ хийлгэх, харьяа байгууллагуудыг нэгдсэн арга зүйгээр хангах

сургалт зохион байгуулах, сургалтын материал, ном, товхимол, гарын авлага хэвлүүлэх зэрэг зардлыг жил бүрийн төсөвт тусган батлуулна.

5.2.Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын арга зүй

5.2.1.нийслэлийн хэмжээнд хэрэгжиж байгаа бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн зүйл, заалтын хэрэгжилтийг тооцохдоо Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6, 7, 8 дугаар зүйлд заасан аргачлалыг баримтална;

5.2.2.нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ энэ журмын 2, 3, 4, 5 дугаар хавсралтаар баталсан шалгуур үзүүлэлтийг ашиглана;

5.2.3.тухайн жилд шинээр байгуулагдсан болон энэ журамд ажил дүгнэх шалгуур үзүүлэлтүүд нь тусгагдаагүй байгууллагын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх тохиолдолд үнэлгээний ажлын хэсэг шалгуур үзүүлэлтийг нь боловсруулан дүгнэнэ;

5.2.4.нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд үнэлгээ хийхээр Нийслэлийн Засаг даргаас томилсон ажлын хэсэг нь байгууллагын үйл ажиллагаанд үнэлгээ хийхдээ дараах дэс дарааллыг баримтална:

а/хяналт-шинжилгээ, үнэлгээнд хамрагдах байгууллагуудаас ирүүлсэн байгууллагын үйл ажиллагааны тайланг судлах;

б/байгууллагын үйл ажиллагааны тайланг судлах явцад зайлшгүй тодруулах, магадлах шаардлагатай асуудлаар газар дээр нь шалгалт хийх.

5.2.5.бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилт, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт болон нийслэлийн удирдлагаас цаг үеийн асуудлаар өгсөн үүрэг, даалгаврын гүйцэтгэлийн үр дүнг дүгнэхдээ Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын "Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн сан"-д байгаа явцын үнэлгээг суурь үнэлгээ болгоно;

5.2.6.нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнгийн ерөнхий үнэлгээг тооцохдоо тайлант хугацааг 100 хувиар тооцож, гүйцэтгэлийг 0-100 хувиар үнэлнэ. Шалгуур үзүүлэлтүүдийн үнэлгээний дундаж хувь нь:

90.0%-100.0% бол "Бүрэн хангалттай";
80.0%-89.9% бол "Хангалттай";
70.0%-79.9% бол "Ажил сайжруулах шаардлагатай";
0.0%- 69.9% бол "Хангалтгүй" гэж үзнэ.

Зургаа.Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын үр дүнтэй
холбогдуулан олгох урамшуулал, хүлээлгэх хариуцлага

6.1.Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хийсэн үнэлгээний дүнг үндэслэн дараах шийдвэрийн төслийг боловсруулан Нийслэлийн Засаг даргад танилцуулна;

6.1.1.тухайн жилийн үйл ажиллагааныхаа үр дүнгээр "Бүрэн хангалттай" үнэлгээ авсан байгууллагыг өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулахаар;

6.1.2.тухайн жилийн үйл ажиллагааныхаа үр дүнгээр "Ажил сайжруулах шаардлагатай" үнэлгээ авсан, эсхүл өмнөх жилийн хүрсэн түвшнээс ажлын үзүүлэлт нь илт буурсан байгууллага, нэгжийн удирдлагад холбогдох хуульд заасны дагуу сануулах, цалин, хөлсийг бууруулах сахилгын шийтгэл ногдуулахаар;

6.1.3. тухайн жилийн үйл ажиллагааныхаа үр дүнгээр "Хангалтгүй" үнэлгээ авсан бол тухайн байгууллага, нэгжийн удирдлагад холбогдох хуульд заасны дагуу албан тушаал бууруулах, ажлаас чөлөөлөх сахилгын шийтгэл ногдуулахаар.

6.2. Дараах зөрчил гаргасан албан тушаалтанд Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хуульд заасны дагуу хариуцлага тооцох саналыг нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж, шийдвэрлүүлнэ:

6.2.1. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын төлөвлөгөөний дагуу хийсэн хяналт-шинжилгээний ажлын явцад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны үнэлгээний дүнгээр хоёр удаа хангалтгүй үнэлгээ авсан, эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт нь буурсан нутгийн захиргааны байгууллагуудын удирдлагад;

6.2.2. хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын мөрөөр хэрэгжүүлэх зөвлөмжийг биелүүлээгүй нутгийн захиргааны байгууллагуудын удирдлагад;

6.2.3. энэ журмын 8 дугаар зүйлд заасан шаардлагуудыг зөрчсөн албан хаагчид;

6.2.4. байгууллагын тайланг дүүргийн Засаг даргын зөвлөл буюу тухайн байгууллагын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлээгүй мэдээлсэн албан хаагчид.

Долоо. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг хэрэгжүүлэх

7.1. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд дурдсан зөвлөмж, дүгнэлтийн дагуу дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

7.1.1. нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын тэргүүний арга, туршлагыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, гарсан алдаа, дутагдлыг засах;

7.1.2. байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах;

7.1.3. харьяа захиргааны байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх талаар үүрэг, чиглэл өгөх, шаардлагатай тохиолдолд зохих удирдамжийн дагуу газар дээр нь хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргах.

7.2. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 11.4-т заасны дагуу захиргааны байгууллага нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, эрдэмтэн, судлаачдыг үнэлгээ хийхэд татан оролцуулах, хэрэглэгчийн болон хөндлөнгийн үнэлгээ хийлгэх, сургалт зохион байгуулах, сургалтын материал, ном, товхимол, гарын авлага хэвлүүлэх зэрэг зардлыг өөрийн байгууллагын төсөвт жил бүр тусган батлуулна.

7.3. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын дүгнэлт, зөвлөмжид үндэслэн бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх үүргийг тухайн зорилтын хэрэгжилтийг хариуцсан байгууллага, албан тушаалтан хүлээнэ.

Найм. Тайлан, мэдээ

8.1. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага энэхүү журмын 1 дүгээр хавсралтаар баталсан хуваарийн дагуу тайлан, мэдээ гаргана.

8.2. Мэдээ, тайлан ирүүлэх хугацааг шаардлагатай тохиолдолд Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас өөрчилж болно. Энэ тохиолдолд албан бичгээр мэдэгдэнэ.

8.3. Шинээр гарсан тогтоол шийдвэрт биелүүлэх хугацааг заасан бол заасан хугацаанд нь, хугацаа заагаагүй тохиолдолд гарсан өдрөөс хойш 3 сарын дараагаас эхлэн хэрэгжилтийн явц, үр дүнг тооцно.

8.4. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ,

үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 8.2-т заасны дагуу байгууллагад өгсөн үүргийн хэрэгжилтийг шийдвэрийн эхэнд нь бичигдсэн агентлагийн дарга, Засаг дарга, ажлын хэсгийн дарга (ахлагч) нэгтгэн мэдээлнэ. Үндэсний хэмжээнд хэрэгжих бодлогын баримт бичгийн нийслэл хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийн хүрсэн түвшин, үр дүнг тухайн арга хэмжээг үндсэн хэрэгжүүлэх байгууллага, холбогдох мэдээллийг хамтран хэрэгжүүлэх байгууллага ирүүлнэ.

8.5.Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд цаг үеийн шаардлагаар шуурхай мэдээ солилцохдоо цаасан суурьтай мэдээг албан хэрэг хөтлөлтийн журмын дагуу, цахим суурьтай мэдээг хүлээн авагчийн цахим шуудангийн хаяг, дотоод удирдлагын системийн захидал харилцааны дэд системийг ашиглан солилцоно.

8.6.Байгууллагаас ирүүлэх бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, холбогдох тайлан, мэдээ нь дараах шаардлагыг хангасан байна:

8.6.1.үйл ажиллагааны гүйцэтгэлийг бүрэн багтаасан, тайлант хугацааг бүрэн хамруулсан байх. Бодлогын баримт бичгийн хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлтийн дагуу хэрэгжүүлсэн үйл ажиллагааны гүйцэтгэлийн хүрсэн түвшин, үр дүнг товч тодорхой байдлаар тодорхойлж, хэрэгжүүлэх хугацаатай уялдуулан чанарын болон тоон шалгуур үзүүлэлтийн дагуу тайлагнасан байх;

8.6.2.холбогдох заавар, журмын дагуу боловсруулсан, албан бичиг хэргийн стандартыг хангасан, үг үсгийн болон хэл найруулгын хувьд алдаагүй, тоо баримт зөрөөгүй байх;

8.6.3.хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, шийдвэр нь үр дүнтэй байсан эсэх мэдээллийг багтаасан байх;

8.6.4.урьдчилан тодорхойлсон хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийн дагуу зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байх;

8.6.5.тайлан дахь хүрсэн түвшний талаарх мэдээллийн үнэн, зөв эсэхийг нягтлан шалгасан байх;

8.6.6.нийслэлийн хэмжээнд тухайн чиглэлээр хийсэн ажлыг бүрэн хамруулж, үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэлд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлийн үндэслэл, шалтгааныг тодорхой гаргасан байх;

8.6.7.хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд оруулдаг бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг 2000 (хоёр мянган) тэмдэгтэд багтааж, үр дүн, үр нөлөөг тайлагнах бөгөөд шаардлагатай бол нотлох баримтыг файлаар хавсаргасан байх;

8.6.8.өмнө хийгдсэн хяналт шинжилгээ, үнэлгээний дүгнэлтээр өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн тусгасан байх;

8.6.9.мэдээ, тайланг байгууллагынхаа хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан нэгжээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэж баталгаажуулсан байх.

Ес.Байгууллагын хагас болон бүтэн жилийн үйл ажиллагааны тайлангийн бүтэц, агуулга

9.1.“Байгууллагын хагас, бүтэн жилийн үйл ажиллагааны тайлан”-г энэ журмын 2, 3, 4, 5 дугаар хавсралтаар баталсан байгууллагын үйл ажиллагааг үнэлэх шалгуур үзүүлэлтийн жишиг загварт тусгагдсан агуулгын дарааллаар боловсруулна.

Арав.Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан

10.1.Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт–шинжилгээ, үнэлгээ хийх, захиргааны байгууллагын үйл ажиллагааг үнэлэх, тайлан илгээх, хүлээн авах, мэдээллийн урсгалыг удирдах, хянах, хадгалах, ашиглах, түгээхэд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан (цаашид “цахим сан” гэх)-г ашиглана.

10.2.Цахим сангийн бүрдүүлэлт, ашиглалт, түүнд тавих хяналтыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс хариуцах бөгөөд дараах асуудлыг хариуцна:

10.2.1.цахим санд өөрт олгосон эрхийн дагуу бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээ, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн заалт нэг бүрийг хяналтад авч хэрэгжүүлэх байгууллагатай холбогдон тайлагнах хугацааг зааж, холбогдох өөрчлөлтийг тухай бүр хийх;

10.2.2.цахим санд өөрт оногдсон эрхийн дагуу нэвтэрч, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт болон байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;

10.2.3.цахим сангийн үйл ажиллагаатай холбоотой сургалт, зааварчилга, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах.

10.3.Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн гишүүд болон нутгийн захиргааны байгууллагын удирдлага цахим санд өөрийн эрхээр нэвтэрч бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, түүний хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны тайлантай танилцаж болно.


10.4.Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд дараах асуудлыг хариуцна:

10.4.1.цахим санд нэвтэрч, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийг хяналтад авч, хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд оруулах;

10.4.2.бодлогын баримт бичиг болон хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн мэдээ, тайланг дүүргийн Засаг даргын зөвлөл, байгууллагын даргын хурлаар хэлэлцүүлсний дагуу цахим санд оруулан баталгаажуулж, холбогдох байгууллагад албан бичгээр хүргүүлэх;

10.4.3.холбогдох байгууллагаас өгсөн үнэлгээтэй тухай бүр танилцаж, өгсөн удирдамж, зааврыг мөрдөн ажиллах.

10.5.Цахим санд мэдээлэл оруулж байгаа байгууллага, албан хаагч мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг хариуцна.



Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын
үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх,
мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журмын
1 дүгээр хавсралт

БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН
БИЕЛЭЛТ БОЛОН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТАЙЛАГНАХ ХУГАЦАА

№	Тайлан, мэдээний нэр	Тайлан, мэдээг хүргүүлэх хугацаа /сар.өдөр/	Тайлан, мэдээ гаргах байгууллагын нэр	Тайлан, мэдээг хүлээн авах байгууллага, нэгж	Давтамж	Тайлагнах дээд шатны байгууллага, албан тушаалтан, хугацаа /сар.өдөр/
		2				6
1	"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого	08.05	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд	Нийслэлийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс	Явцыг- жил тутам, ХШУ-5 жил тутам	Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн терийн захиргааны төв байгууллага 09.01-ний өдрийн дотор
2	Хүний хөгжлийн зорилтот хөтөлбөр	09.05	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд	Нийслэлийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс	Явцыг- жил тутам, ХШУ-5 жил тутам	Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн терийн захиргааны төв байгууллага 10.01- ний өдрийн дотор
3	Нийгмийн хөгжлийн зорилтот хөтөлбөр	09.05	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд	Нийслэлийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс	Явцыг- жил тутам, ХШУ-5 жил тутам	Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн терийн захиргааны төв байгууллага 10.01- ний өдрийн дотор
4	Эдийн засаг болон дэд бүтцийн хөгжлийн зорилтот хөтөлбөр	09.05	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд	Нийслэлийн ЗДТГ-ын Эдийн засгийн хөгжил, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтэс, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс	Явцыг- жил тутам, ХШУ-5 жил тутам	Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн терийн захиргааны төв байгууллага 10.01- ний өдрийн дотор
5	Байгаль орчны зорилтот хөтөлбөр	09.05	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд	Нийслэлийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс	Явцыг- жил тутам, ХШУ-5 жил тутам	Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн терийн захиргааны төв байгууллага 10.01- ний өдрийн дотор
6	Засаглалын зорилтот хөтөлбөр	09.05	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд	Нийслэлийн ЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс	Явцыг- жил тутам, ХШУ-5 жил тутам	Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн терийн захиргааны төв байгууллага 10.01- ний өдрийн дотор

7	Бүсийн хөгжлийн хөтөлбөр	зорилтот	09.05	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд	Нийслэлийн 3ДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс	Явцыг- жил тутам, ХШУ-5 жил тутам	Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага 10.01- ний өдрийн дотор
8	Үндэсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилтот хөтөлбөр		09.05	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд	Нийслэлийн 3ДТГ-ын Эдийн засгийн хөгжил, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтэс	Явцыг- жил тутам, ХШУ-5 жил тутам	Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага 10.01- ний өдрийн дотор
9	Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл		12.15	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд	Нийслэлийн 3ДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс	Явц-жил тутам	Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага 01.01- ний өдрийн дотор
10	Засгийн газрын ажиллагааны хөтөлбөр	үйл	06.15 12.15	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд	Нийслэлийн 3ДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс	Хагас жил тутам, - Сар бүр цахим системээр тайлагнана	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар 01.01- ний өдрийн дотор, 07.01- ний өдрийн дотор
11	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө	жилийн	05.15 12.15	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд	Нийслэлийн 3ДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс	Хагас жил тутам,	Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага 01.01- ний өдрийн дотор, 06.15-ны өдрийн дотор
12	Нийслэл хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл		02.15	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд	Нийслэлийн 3ДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс	Жил тутам	Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага 03.01- ний өдрийн дотор
13	Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр	үйл	01.15	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд	Нийслэлийн 3ДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс	Жил тутам	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар 02.01- ний өдрийн дотор
14	Нийслэл хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө	жилийн	01.15	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд	Нийслэлийн 3ДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс	Жил тутам	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар 02.01- ний өдрийн дотор
15	Хуульд нийцүүлэн хүчингүй болсон тооцсон болон хугацаа дууссан бодлогын баримт бичгийн тайлан		06.25 12.25	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд	Нийслэлийн 3ДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс	Жилд 2 удаа	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар Хүчингүй болсон, хугацаа дууссан өдрөөс хойш 6 сарын дотор
16	Монгол Улсын хууль, УИХ-ын шийдвэр, Ерөнхийлөгчийн зарлиг, УАБЗ-ийн зөвлөмж, Засгийн газрын шийдвэрийн биелэлт		06.25 12.25	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд	Нийслэлийн 3ДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс	Хагас жил тутам, Сар бүр цахим системээр тайлагнана	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар 02.15 06.25-ны өдрийн дотор
17	Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт		02.20	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд	Нийслэлийн 3ДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс	Жил тутам	Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага 03.01- ний өдрийн дотор

18	Стратеги төлөвлөгөөний хэрэгжилт	02.20	Нийслэлийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс	Нийслэлийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс	Жил тугам	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар 03.01- ний өдрийн дотор
19	Байгууллагын гүйцэтгэлийн хэрэгжилт	02.20	Нийслэлийн ЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс	Нийслэлийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс	Жил тугам	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар 03.01- ний өдрийн дотор
20	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн биелэлт	02.20	Нийслэлийн ЗДТГ-ын Хүний нөөцийн удирдлагын хэлтэс	Нийслэлийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс	Жил тугам	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар 03.01- ний өдрийн дотор
21	Байгууллагын ил тод байдлын үнэлгээ	02.20	Нийслэлийн ЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Хүний нөөцийн удирдлагын хэлтэс	Нийслэлийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс	Жил тугам	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар 03.01- ний өдрийн дотор
22	Тухайн жилийн үйл ажиллагааны хяналт- шинжилгээ, үнэлгээний тайлан	02.20	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд	Нийслэлийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс	Жил тугам	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар 03.01- ний өдрийн дотор
23	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн хэрэгжилтийн тайлан /Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын 5 дугаар хавсралтаар/	03.25 06.25 09.25 12.25	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд	Нийслэлийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс	Улирал тугам	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба 04.10 07.10 10.10 01.10
24	Нийслэлийн Засаг даргын захирамж, албан даалгаврын хэрэгжилтийн тайлан /Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын 5 дугаар хавсралтаар/	03.25 06.25 09.25 12.25	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд	Нийслэлийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс	Улирал тугам	Нийслэлийн Засаг даргад 04.10 07.10 10.10 01.10
25	Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн дээр өгсөн үүргийн биелэлтийн мэдээ	Шуурхай зөвлөгөөний өмнөх 7 хоногийн Пүрэв гарагт	Нутгийн захиргааны байгууллагууд	Нийслэлийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс	14 хоног тугам	Нийслэлийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнд танилцуулах

26	Нийслэлийн төсвийн хөрөнгөөр худалдан авах ажиллагааны төлөвлөгөө	Нийслэлийн төсөв батлагдсанаас хойш 5 өдрийн дотор	НХААГ	НЗДТГ	Жил тутам	Сангийн яам Нийслэлийн төсөв батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор
27	Тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайлан	12 дугаар сарын 01-ний дотор	Захиалагчийн хяналт тавьж буй байгууллагууд	Нийслэлийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс	Жил тутам	Сангийн яам 1 дүгээр сарын 15-ны дотор
28	Улс, орон нутаг, Орон нутгийн хөгжлийн сан, нийслэлийн замын сангийн хөрөнгө, урсгал зардал, өөрийн хөрөнгөөр санхүүжиж байгаа төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны явцын мэдээ	Тухай бүр	Эрх шилжсэн байгууллагууд	Report.ub-procurement.mn-д	Тухай бүр	Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурал болон Нийслэлийн Удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнд танилцуулах
29	Улс, орон нутаг, Орон нутгийн хөгжлийн сан, нийслэлийн замын сангийн хөрөнгө, урсгал зардал, өөрийн хөрөнгөөр санхүүжиж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, санхүүжилтын явцын мэдээ	14 хоног тутам	Захиалагчийн хяналт тавьж буй байгууллагууд	Нийслэлийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс	14 хоног тутам	Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурал болон Нийслэлийн Удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнд танилцуулах
30	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар Засгийн газар, түншлэгч орон, олон улсын санхүүгийн байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний нэгдсэн танилцуулга	04.01 07.01 10.01 12.01	Төсөл хэрэгжүүлэх нэгж	Нийслэлийн ЗДТГ-ын Эдийн засгийн хөгжил, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтэс	Улирал тутам	Холбогдох яам 02.01
31	Цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрийн орлогын зарцуулалтын тайлан	01.05	Дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штаб	Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штаб	Жил тутам	Батлан хамгаалах яам 01.15
32	Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа иргэдийн мэдээ	03.15 10.15	Дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штаб	Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штаб	Жилд 2 удаа	Батлан хамгаалах яам 03.20 10.20
33	Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаагчдын мэдээ	03.15 10.15	Дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штаб	Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штаб	Жилд 2 удаа	Батлан хамгаалах яам 03.20 10.20
